

**“ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ”-ИЙН
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦОО**

АГУУЛГА

| | |
|---|----|
| УДИРТГАЛ | 3 |
| Үнэлгээний хамрах хүрээ..... | 4 |
| Нэг. Төрийн байгууллагын зардал | 7 |
| 1.1. Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, зарцуулах хугацаа | 7 |
| 1.2. Ажил үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөц | 10 |
| 1.3. Нийт гарах хүний нөөцийн зардлын тооцоо, холбогдох нэмэлт зардал .. | 13 |
| 1.4. Бусад нэмэлт зардал, нийт зардлын урьдчилсан тооцоо, хувилбар..... | 16 |
| Хоёр. Иргэнд үүсэх зардал, ачаалал..... | 18 |
| 1.1. Иргэдэд шинээр үүссэн үүрэг | 18 |
| 1.2. Хугацаа, зардлын тооцоо..... | 19 |
| 1.3. Тоон үзүүлэлт, нийт ачаалал /зардал, хугацаа/ | 19 |
| Гурав. Хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардал | 21 |
| Үнэлгээний үр дүн | 22 |
| Хавсралт 1: Хуулийн төсөлд тусгасан төрийн байгууллагын үүрэг | 23 |
| Хавсралт 2: Хуулийн төсөлд тусгагдсан хэрэгжүүлэгч байгууллагын үүргийн стандарт үйл ажиллагаа | 25 |

Хүснэгтийн жагсаалт

| | |
|--|----|
| Хүснэгт 1. Зардал тооцох үе шат | 4 |
| Хүснэгт 2. Шүүх болон бусад байгууллагын хүний нөөцийн зардлыг тооцох зохицуулалт | 5 |
| Хүснэгт 3. Хэрэгжүүлэгч байгууллагуудын үүрэг | 7 |
| Хүснэгт 4. Шүүхийн гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагаанд зарцуулах цаг | 9 |
| Хүснэгт 5. Сүүлийн 3 жилийн Иргэний хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн иргэний хэргийн тоо /дунджаар/ | 10 |
| Хүснэгт 6. Шүүхэд бий болон хүний нөөцийн хэрэгцээ /нийт цаг/ | 11 |
| Хүснэгт 7. ШЕЗ болон УДШ-д бий болох хүний нөөцийн хэрэгцээ /нийт цаг/ | 12 |
| Хүснэгт 8. Шүүхийн болон бусад байгууллагын гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагаанд шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээ /орон тоо/ | 13 |
| Хүснэгт 9. Шаардлагатай орон тооны цалингийн зэрэглэл, хэмжээ | 14 |
| Хүснэгт 10. Шүүгчийн цалингийн зардал /нийт/ | 14 |
| Хүснэгт 11. Шүүхийн хүний нөөцийн зардал | 14 |
| Хүснэгт 12. Нэг албан хаагчид ногдох материаллаг зардлын хэмжээ | 14 |
| Хүснэгт 13. Шүүхийн хүний нөөцийн нийт зардал | 15 |
| Хүснэгт 14. Иргэнд шинээр ачаалал бий болгосон заалт | 18 |
| Хүснэгт 15. Үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай хугацаа, зардал | 19 |
| Хүснэгт 16. Иргэдэд бий болох нийт зардал | 20 |
| Хүснэгт 17. Төрийн байгууллагын чиг үүрэг | 23 |
| Хүснэгт 18. Хэрэгжүүлэгч байгууллагуудын гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагаа .. | 25 |

УДИРТГАЛ

Энэхүү тайланд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зардлын тооцоог Засгийн газрын 2016 оны 59 тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын /цаашид “Аргачлал” гэх/ дагуу гүйцэтгэж, хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах захиргааны зардлыг урьдчилан тооцов.

Хууль тогтоомжийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо нь 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр хэрэгжиж буй Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хийгддэг бөгөөд тодорхой харилцааг зохицуулах зорилгоор шинээр боловсруулж буй хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээр төрийн байгууллага, хуулийн этгээд болон хувь хүнд хэр хэмжээний зардал, ачаалал үүсэх магадлалыг урьдчилан гаргах зорилготой. Энэ нь аливаа хууль тогтоомжийн улмаас улс орны эдийн засаг болон иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсч байгаа захиргааны зардал, ачааллыг аль болох бага үүсгэх зохицуулалтын хувилбарыг боловсруулахад чухал ач холбогдолтой.

ИХШХШТХ-ийн шинэчилсэн найруулгын төсөл нь одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуульд тодорхой заагдаагүй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон хэргийн оролцогчдийн талаарх процессын зохицуулалтыг илүү дэлгэрүүлж, шүүхээс гаргах эрхийн акт болон түүнийг шийдвэрлэх журмыг нарийвчлан тусгасан. Улмаар одоогийн хуульд тусгагдаагүй бага үнийн дүнтэй хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх тогтолцоо, урьдчилсан шүүх хуралдаан зэрэг шинэлэг зохицуулалтыг тусгасан байна.

Хэдий тийм ч хуулийн төлсөөр одоогийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цоо шинээр өөрчлөх агуулга байхгүй бөгөөд дийлэнх тохиолдолд одоогийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны практикт тогтмол хийгддэг ажиллагааг хуульд нарийвчлан тусгасан тул хуулийн төслийн дийлэнх зохицуулалт нь урьд хэрэгжиж байсан зохицуулалтыг дэлгэрүүлсэн, тодорхой болгосон учир шинээр зардал тооцох шаардлагагүй юм.

Тиймээс энэхүү хуулийн төслийн зардлын тооцооны судалгаагаар ИХШХШТХ-ийн шинэчилсэн найруулгын төслөөс одоогийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд байхгүй бөгөөд шинээр бий шүүх болон хэргийн оролцогч, бусад байгууллагад үүрэг бий болгож буй зохицуулалтыг түүвэрлэн зардлын тооцоог гаргасан болно. Улмаар хуулийн төсөл батлагдснаар төрийн байгууллагад үүсэх зардлыг тоймлон гаргаснаар хуулийн хэрэгжилтийг бүрэн хангахад шаардлагатай нэмэлт зардлыг урьдчилан тооцох нь тус тайлангийн үндсэн зорилго байх болно.

Үнэлгээний хамрах хүрээ

Хуулийн төслөөс сонгон зардал тооцох зохицуулалт буюу үнэлгээний хүрээний тухайд Аргачлалын дагуу иргэн, хуулийн этгээдэд шинээр үүссэн үүрэг, харилцаанаас үүсэх зардал, ачааллыг тооцох буюу өмнө байсан харилцааг зохицуулсан зохицуулалтад өөрчлөлт ороогүй бол зардал, ачааллыг тооцдоггүй. Төрийн байгууллагын хувьд өмнө нь хэрэгжүүлж байсан чиг үүрэгт өөрчлөлт ороогүй бол мөн зардал тооцохгүй бөгөөд хуулийн төсөлд хамаарах үндсэн хэрэгжүүлэгч агентлагт үүсэх ачаалал болон улсын төсөвт их хэмжээгээр үүсгэх зардлыг голчлон тооцох зарчмыг баримталдаг.

Тус хуулийн төслийн хувьд хуулийн этгээдэд шинэ ачаалал үүсгэх зохицуулалт тусгагдаагүй. Иймд хуулийн төслөөс дараах зохицуулалтуудыг сонгон төрийн байгууллага, иргэнд үүсэх зардал, ачааллыг тооцов. Үүнд:

1. Төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцох зохицуулалт

ИХШХШТХ нь шүүхээс иргэний хэргийг шийдвэрлэхдээ баримтлах зарчим, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат болон тухайн ажиллагаанд шүүх болон шүүгчийн зүгээс авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зохицуулдаг. Тиймээс тус хуулийн төслийн зардлын тооцоо нь дийлэнхдээ шүүхэд үүсэх ачааллыг тооцох замаар шүүх байгууллагад нэмэлтээр үүсэх зардлыг тооцох болно. Өөрөөр хэлбэл тус хуулийн төслөөр шүүхээс бусад төрийн байгууллагад шууд үүрэг болгосон зохицуулалт байхгүй бөгөөд төрийн байгууллагад үүсэх зардлыг тооцох гэдэг нь шүүх байгууллагад үүсэх зардлыг ойлгоно. Харин хуулийн төсөлд тусгагдснаар Шүүхийн ерөнхий зөвлөлд шинжилгээ хийх боломжтой этгээдийн талаар мэдээллийн сан бүрдүүлэх, Улсын Дээд шүүхэд зарим төрлийн аргачлал, загвар боловсруулж батлах үүрэг ногдуулсан тул тус үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг нэмэлтээр тооцохоор сонгов. Ингэхдээ Аргачлалд заасны дагуу төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг дараах үе шатаар тус бүр тооцно. Үүнд:

Хүснэгт 1. Зардал тооцох үе шат

Шүүхэд үүсэх зардал, ачаалал

- Үүргийг тогтоох
- Хүний нөөцийг тодорхойлох
- Гарах зардлыг тооцох
- Зардлыг нэгтгэн тооцож гаргах
- Хувилбарыг нягталж, танилцуулах

Өөрөөр хэлбэл шүүхэд үүсэх зардлын хүрээнд тухайн ажил үйлчилгээг /шинээр бий болох үүргийг/ гүйцэтгэхэд шаардагдах **(а) хүний нөөцийн хэрэгцээг** тодорхойлж, түүнд шаардагдах зардал болон холбогдох бусад **(б) нэмэлт зардлыг** тооцно. Үүнд:

(а). Хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох зохицуулалт

Аргачлалаар тогтоосон үе шат, дарааллын дагуу стандарт үйл ажиллагааг тодорхойлж, тэдгээрт зарцуулах цаг хугацааг тооцох боломжтой, шүүхийн дараах үүргийн хүний нөөцийн зардлыг тооцон гаргана. Үүнд:

Хүснэгт 2. Шүүх болон бусад байгууллагын хүний нөөцийн зардлыг тооцох зохицуулалт

| № | Зохицуулалт | Зардал тооцох үүрэг |
|--|---|--|
| 1. Иргэний хэргийн анхан шатны шүүх | | |
| 1 | 67.3.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны <u>мэдэгдлийг шүүх гуравдагч этгээдэд хүргүүлнэ.</u> | <i>Шүүхээс гуравдагч этгээдэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэдэгдлийг хүргүүлэх</i> |
| 2 | 67.4. <u>Шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэдэгдлийг хэргийн бусад оролцогчдод хүргүүлнэ.</u> | <i>Шүүхээс хэргийн бусад оролцогчдод хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэдэгдлийг хүргүүлэх</i> |
| 3 | 251.1.Хуульд өөрөөр заагаагүй бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой баримт бичгийг <u>шүүх өөрийн санаачилгаар хэргийн оролцогчид хүргүүлнэ.</u> | <i>Шүүхээс хэргийн оролцогчид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой баримт бичгийг хүргүүлэх</i> |
| 4 | 252.1.Хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд <u>баримт бичгийг баталгаат шуудангаар, эсхүл шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлнэ.</u> | <i>Баримт бичгийг баталгаат шуудан, эсхүл биечлэн хүргэх</i> |
| 5 | 256.4.Хэргийн оролцогчийн оршин суугаа/оршин байгаа/ болон бусад хүргэх ёстой хаяг мэдэгдэхгүй байгаа тохиолдолд улсын бүртгэлийн байгууллагаас оршин суух хаягийг тодруулах ажиллагааг <u>шүүх санаачилгаараа хийнэ.</u> | <i>Улсын бүртгэлийн байгууллагаас хэргийн оролцогчийн хаягийг тодруулах</i> |
| 6 | 262.3.Шүүх өөрийн санаачилгаар баримт бичгийн агуулгыг баримт бичиг хүлээн авах ёстой этгээдэд <u>хоёр удаа нийтэд мэдээлэх замаар мэдэгдэнэ.</u> | <i>2 удаа шүүхээс баримт бичгийн агуулгыг нийтэд мэдээлэх</i> |
| 7 | 263.1.Нийтэд мэдээлэх замаар баримт бичиг хүргэхдээ шүүх нь бичиг баримтыг хадгалж ямар ч үед баримт бичиг хүлээн авах ёстой этгээдэд гардуулах боломжтой тухай <u>шүүхийн нийтэд мэдээлэх хэрэгслээр мэдээлнэ.</u> | <i>Нийтэд мэдээлэх хэрэгслээр дамжуулан нийтэд мэдээлэх</i> |
| 2. Шүүхийн ерөнхий зөвлөл | | |
| 8 | 188.3.Шүүхийн ерөнхий зөвлөл шинжилгээ хийх боломжтой этгээдийн талаар мэргэшсэн чиглэлээр нь <u>мэдээллийн сан бүрдүүлнэ.</u> | <i>Шинжилгээ хийх боломжтой этгээдийн талаар мэдээллийн сан үүсгэх</i> |

| | | |
|---------------------------|--|--|
| 9 | 257.3.Энэ хуулийн 257.2-т заасан цахим шуудангийн хаягаа мэдүүлэх <u>баримт загварыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална.</u> | <i>Цахим шуудангийн хаяг мэдүүлэх баримтын загвар батлах</i> |
| 3. Улсын Дээд Шүүх | | |
| 10 | 367.2.Бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэлийн хариу тайлбарын <u>загварыг Улсын дээд шүүх батална.</u> | <i>Нэхэмжлэл, хариу тайлбарын загвар батлах</i> |
| 11 | 377.2.Энэ хуулийн 377.1-д заасан шийдвэрийн боловсруулах <u>аргачлалыг Монгол Улсын дээд шүүхээс батална.</u> | <i>Шүүхийн шийдвэр боловсруулах аргачлал батлах</i> |

(б). Нэмэлт зардал тооцоход хамаарах зохицуулалт

Бусад нэмэлт зардлын */хүний нөөцийн бус зардлын/* хүрээнд сургалт зохион байгуулах, мэдээллийн сан үүсгэх зэрэг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн зардлыг тойм байдлаар баримжаалан гаргах боловч хуулийн төсөлд нэмэлт зардал үүсэх зохицуулалт тусгагдаагүй байна. Иймд нэмэлт зардлыг тооцох шаардлагагүй гэж үзлээ.

2. Иргэнд шинээр үүсэх зардал, ачааллыг тооцох зохицуулалт:

Хуулийн төсөлд иргэнд буюу хэргийн оролцогчид шинээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар гуравдагч этгээдэд мэдэгдэх хүрээнд шүүхэд бичгээр мэдэгдэл гаргах, урьдчилсан хуралдаанд хэлэх тайлбараа бичгээр гаргах, хүсэлт гаргах зэрэг одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ИХШХШтХ-д тодорхой заагдаагүй шинэ үүргүүдийг бий болгосон байна. Тиймээс одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй хуульд зааснаас гадна хуулийн төсөл батлагдснаар иргэнд шинээр нэмэлт үүрэг үүсгэх боломжтой заалтуудыг сонгож иргэнд үүсэх зардлыг тооцов.

Нэг. Төрийн байгууллагын зардал

Энэ хэсэгт хуулийн төслийн шүүх болон бусад байгууллагад үүрэг оногдуулсан зохицуулалтууд нь тухайн байгууллагад буюу төрд хэдий хэр ачаалал, зардал үүсгэх магадлалтайг баримжаалан тооцно. Төрийн байгууллагад үүсэх ачаалал, зардлын хэмжээг урьдчилан тооцох нь тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх төсөв, санхүүжилтийн хэмжээ, хэрэгцээ, шаардлагыг тогтоох, мөн хэрэгжих боломжийг тодорхойлоход ач холбогдолтой.

Төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардлыг дараах үе шатаар тооцно. Үүнд:

- Үүргийг тогтоох
- Хүний нөөцийг тодорхойлох
- Гарах зардлыг тооцох
- Зардлыг нэгтгэн тооцож гаргах
- Хувилбарыг нягталж, танилцуулах

Үүнд, стандарт үйл ажиллагааг тогтоож, хүний нөөцийн зардал буюу зарцуулах цаг хугацааг тооцох боломжтой үүргийг дээрх дарааллын дагуу тооцож нэгтгэн гаргах бол сургалт зохион байгуулах, мэдээллийн сан үүсгэх зэрэгт шаардагдах санхүүгийн зардлыг бусад нэмэлт зардлын хүрээнд тойм байдлаар баримжаалан гаргана.

1.1. Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, зарцуулах хугацаа

Хуулийн төсөлд Иргэний хэргийн анхан шатны шүүх, Шүүхийн Ерөнхий Зөвлөл, Улсын Дээд шүүхэд шинээр үүрэг оноосон зохицуулалтууд тусгагдсан байна /Хавсралт 1/. Эдгээрээс тохиолдлын тоог нь тогтоох боломжгүй болон тогтоох шаардлагагүй үйл ажиллагаа буюу хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, бодлого боловсруулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэхэд гарах зардлыг тооцохгүй.

Ийнхүү Аргачлалд заасны дагуу хуулийн төсөл дэх төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, ажил үйлчилгээнд хамааралтай бүх байгууллагыг биш шинэ чиг үүрэг нэмэгдэж байгаа гол хэрэгжүүлэгч байгууллагуудыг сонгон зардал, ачааллыг тооцов. Ингэхдээ стандарт үйл ажиллагааг тогтоох боломжтой үүрэг бүхий байгууллагуудын ачаалал, хүний нөөцийг аргачлалын дагуу үе шаттайгаар тооцох бөгөөд хүний нөөцийн бус, бусад зардлыг нэмэлт зардал тооцох хэсэгт шаардлагатай мөнгөн зардлыг нь тоймлон тооцно.

Хуулийн төсөлд стандарт үйл ажиллагааг нь тооцох шаардлагатай салбарын байгууллагуудын дараах үүрэг байна. Үүнд:

Хүснэгт 3. Хэрэгжүүлэгч байгууллагуудын үүрэг

| № | Зохицуулалт | Зардал тооцох үүрэг |
|---|--|---------------------|
| | 1. Иргэний хэргийн анхан шатны шүүх | |

| | | |
|----------------------------------|--|---|
| 1 | 67.3.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэдэгдлийг шүүх гуравдагч этгээдэд хүргүүлнэ. | Шүүхээс гуравдагч этгээдэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэдэгдлийг хүргүүлэх |
| 2 | 67.4.Шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэдэгдлийг хэргийн бусад оролцогчдод хүргүүлнэ. | Шүүхээс хэргийн бусад оролцогчдод хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэдэгдлийг хүргүүлэх |
| 3 | 251.1.Хуульд өөрөөр заагаагүй бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой баримт бичгийг шүүх өөрийн санаачилгаар хэргийн оролцогчид хүргүүлнэ. | Шүүхээс хэргийн оролцогчид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой баримт бичгийг хүргүүлэх |
| 4 | 252.1.Хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд баримт бичгийг баталгаат шуудангаар, эсхүл шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлнэ. | Баримт бичгийг баталгаат шуудан, эсхүл биечлэн хүргэх |
| 5 | 256.4.Хэргийн оролцогчийн оршин суугаа/оршин байгаа/ болон бусад хүргэх ёстой хаяг мэдэгдэхгүй байгаа тохиолдолд улсын бүртгэлийн байгууллагаас оршин суух хаягийг тодруулах ажиллагааг шүүх санаачилгаараа хийнэ. | Улсын бүртгэлийн байгууллагаас хэргийн оролцогчийн хаягийг тодруулах |
| 6 | 262.3.Шүүх өөрийн санаачилгаар баримт бичгийн агуулгыг баримт бичиг хүлээн авах ёстой этгээдэд хоёр удаа нийтэд мэдээлэх замаар мэдэгдэнэ. | 2 удаа шүүхээс баримт бичгийн агуулгыг нийтэд мэдээлэх |
| 7 | 263.1.Нийтэд мэдээлэх замаар баримт бичиг хүргэхдээ шүүх нь бичиг баримтыг хадгалж ямар ч үед баримт бичиг хүлээн авах ёстой этгээдэд гардуулах боломжтой тухай шүүхийн нийтэд мэдээлэх хэрэгслээр мэдээлнэ. | Нийтэд мэдээлэх хэрэгслээр дамжуулан нийтэд мэдээлэх |
| 2. Шүүхийн ерөнхий зөвлөл | | |
| 8 | 188.3.Шүүхийн ерөнхий зөвлөл шинжилгээ хийх боломжтой этгээдийн талаар мэргэшсэн чиглэлээр нь мэдээллийн сан бүрдүүлнэ. | Шинжилгээ хийх боломжтой этгээдийн талаар мэдээллийн сан үүсгэх |
| 9 | 257.3.Энэ хуулийн 257.2-т заасан цахим шуудангийн хаягаа мэдүүлэх баримт загварыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална. | Цахим шуудангийн хаяг мэдүүлэх баримтын загвар батлах |
| 3. Улсын Дээд Шүүх | | |
| 10 | 367.2.Бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэлийн хариу тайлбарын загварыг Улсын дээд шүүх батална. | Нэхэмжлэл, хариу тайлбарын загвар батлах |

| | | | |
|----|--|-----------------------------|------------------|
| 11 | 377.2.Энэ хуулийн 377.1-д заасан шийдвэрийн боловсруулах аргачлалыг Монгол Улсын дээд шүүхээс батална. | Шүүхийн боловсруулах батлах | шийдвэр аргачлал |
|----|--|-----------------------------|------------------|

Эдгээрийн стандарт үйл ажиллагааг тодорхойлох, зарцуулах хугацааг нь гаргахдаа одоо хэрэгжиж байгаа адил төстэй үйлчилгээ байгаа эсэхийг судалж, холбогдох шүүгч нараас ярилцлагын судалгаа авсан бөгөөд мөн Шүүгчийн ажлын ачаалал тодорхойлох судалгааг¹ ашиглан хэрэгжүүлэх алхам, хугацааг гаргасан. Тус судалгаанд үндэслэн шүүх байгууллагын гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагааг алхам тус бүрээр нарийвчлан тодорхойлж /Хавсралт 2/, түүнд зарцуулах нийт хугацааг дараах байдлаар гаргав. Үүнд:

Хүснэгт 4. Шүүхийн гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагаанд зарцуулах цаг

| Хариуцах байгууллага | Үйл ажиллагаа буюу үүрэг | Зарцуулах хугацаа /цаг/ |
|----------------------|---|-------------------------|
| Иргэний хэргийн шүүх | Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх мэдэгдлийг гуравдагч этгээдэд хүргүүлэх | 0.66 |
| | Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх мэдэгдлийг хэргийн бусад оролцогчдод хүргүүлэх | 0.66 |
| | Шүүхээс хэргийн оролцогчид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой баримт бичгийг хүргүүлэх <i>Баримт бичгийг баталгаат шуудан, эсхүл биечлэн хүргүүлэх</i> | 1.78 |
| | Улсын бүртгэлийн байгууллагаас хэргийн оролцогчийн хаягийг тодруулах | 1.16 |
| | Шүүх өөрийн санаачилгаар баримт бичгийн агуулгыг баримт бичиг хүлээн авах ёстой этгээдэд хоёр удаа нийтэд мэдээлэх замаар мэдэгдэх | 1.5 |
| | Нийтэд мэдээлэх замаар баримт бичиг хүргэхдээ шүүх нь бичиг баримтыг хадгалж ямар ч үед баримт бичиг хүлээн авах ёстой этгээдэд гардуулах боломжтой тухай шүүхийн нийтэд мэдээлэх хэрэгслээр мэдээлэх | 0.5 |

¹ Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүгчийн ажлын ачаалал тодорхойлох судалгаа, Хүснэгт 20. Шүүгчийн ажлын ачаалал тодорхойлох үзүүлэлт /Иргэний хэргийн анхан шатны шүүх/, хуудас 32.

| | | |
|------------------------|---|----|
| Шүүхийн Ерөнхий Зөвлөл | Шинжилгээ хийх боломжтой этгээдийн талаар мэдээллийн сан үүсгэх | 36 |
| | Цахим шуудангийн хаяг мэдүүлэх баримтын загвар батлах | 19 |
| Улсын Дээд Шүүх | Бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэл, хариу тайлбарын загвар батлах | 19 |
| | Бага үнийн дүнтэй хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр боловсруулах аргачлал батлах | 19 |

1.2. Ажил үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөц

Энэ хэсэгт тухайн ажил үйлчилгээг жилд хэдэн удаа гүйцэтгэх тоог урьдчилан таамагласнаар шаардлагатай нийт хүний нөөцийг тооцож гаргана. Ингэхдээ тохиолдлын тоог үйл ажиллагаа тус бүрийн хүрээнд зохих статистик мэдээ, дундаж үзүүлэлтэд тулгуурлан гаргасан бөгөөд шүүхийн хувьд шинээр ирж буй үүрэгт зарцуулах хүний нөөцийг урьдчилан гаргахын тулд мөн тухайн харилцаа тус бүрийн өмнөх жилүүдийн тоон үзүүлэлтийн дундажыг тооцоолон тохиолдлын тоог авч үзсэн.

Тодруулбал, Монгол Улс дахь нийт Иргэний хэргийн анхан шатны шүүхийн сүүлийн 3 жилийн шийдвэрлэсэн хэргийн дунджаар тохиолдлын тоог баримжаалан үзсэн бөгөөд дэлгэрэнгүйг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 5. Сүүлийн 3 жилийн Иргэний хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн иргэний хэргийн тоо /дунджаар/²

| | 2020 он ³ | 2021 он ⁴ | 2022 он ⁵ | Нийт дундаж |
|--|----------------------|----------------------|----------------------|---------------|
| | 53,678 | 45,444 | 57,663 | 52,261 |
| Үүнээс : | | | | |
| ИХШХШТХ-ийн 115 дугаар зүйлд зааснаар шийдвэрлэсэн хэрэг | 30,651 | 22,551 | 25,159 | 26,120 |
| ИХШХШТХ-ийн 74 дүгээр зүйлд зааснаар шийдвэрлэсэн хэрэг | 15,738 | 15,819 | 20,275 | 17,277 |

² 2020, 2021, 2022 оны Иргэний хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоон мэдээллийг ШЕЗ-өөс гаргасан жил бүрийн “Шүүн таслах ажиллагааны нэгдсэн тайлан”-аас авав. Дэлгэрэнгүйг ШЕЗ-ийн [judcouncil.mn](https://drive.google.com/file/d/1q4Q7p7zoewazochw1ZIB22zHjxbnhZWU/view)-ээс үзэх боломжтой.

³“Монгол Улсын Шүүхийн тайлан 2020” ШЕЗ, 2021 он. 222-223 тал.
<https://drive.google.com/file/d/1q4Q7p7zoewazochw1ZIB22zHjxbnhZWU/view>

⁴“Монгол Улсын Шүүхийн тайлан 2021” ШЕЗ, 2022 он. 243-244 тал.
<https://drive.google.com/file/d/1idrOGcvKAIUwiu0FN-StVBBQOOTeWRpH/view>

⁵“Монгол Улсын Шүүхийн тайлан 2022” ШЕЗ, 2023 он. 259-260 тал.
https://drive.google.com/file/d/18oxr2jarQc1JslTkXo_IIXOvAHcRx_Od/view

| | | | | |
|--|--------|--------|--------|---------------|
| ИХШХШтХ-ийн 117 дүгээр зүйлд зааснаар хэрэгсэхгүй болгосон хэрэг | 7,289 | 7,074 | 11,738 | 8,700 |
| Онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэсэн хэрэг | 17,034 | 11,656 | 13,157 | 13,949 |

Гэхдээ дээрх сүүлийн 3 жилийн Иргэний хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн дундаж тоо нь хуулийн төсөл батлагдсан тохиолдолд шүүхэд шинээр бий болгож байгаа үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай тохиолдлын тоог баримжаалж тооцоход ашиглах бөгөөд хуулийн төслийн 67 дугаар зүйлийн 67.3, 67.4-т заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар гуравдагч этгээд болон бусад оролцогчид мэдэгдэх ажиллагааг одоогийн ИХШХШтХ-ийн 115 дугаар зүйл буюу шүүхийн шийдвэр гарсан хэргээс тооцох нь үндэслэлтэй болно.

Өөрөөр хэлбэл, хэргийг хэрэгсэхгүй болгосон, хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн хэрэгт гуравдагч этгээд болон бусад оролцогч оролцохгүй байх нь түгээмэл учир ИХШХШтХ-ийн 115 дугаар зүйлийг баримтлан шийдвэрлэсэн нийт хэргийн тоо сүүлийн гурван жилийн дунджаар 26,120 хэрэг байх бөгөөд үүнээс ойролцоогоор ¼-т нь гуравдагч этгээд болон бусад этгээд оролцоно гэж үзвэл тус заалтыг хэрэгжүүлэх тохиолдлын тоо 6,530 байна.

Харин хуулийн төслийн 251 дүгээр зүйлд заагдсан шүүхээс хэргийн оролцогчдод баримт бичиг хүргүүлэх ажиллагааг бүх хэрэгт хийгдэх боловч практик дийлэнхдээ хэргийн оролцогчид өөрсдөө шүүхэд ирж бичиг баримтыг хүлээн авдаг байдлыг харгалзан үзэж баталгаат шуудан эсхүл биечлэн хүргэх тохиолдлын тоог ИХШХШтХ-ийн 115 дугаар зүйлийг баримтлан шийдвэрлэсэн нийт хэргийн тоо сүүлийн гурван жилийн дунджаар 26,120 хэргийн 1/5 гэж тооцож тохиолдлын тоо 5,224 байна.

Хэргийн оролцогчийн хаягийг улсын бүртгэлийн байгууллагаас тодруулах, шүүх өөрийн санаачилгаар баримт бичгийн агуулгыг нийтэд хоёр удаа мэдээлэх, шүүхийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд мэдээлэх тухай хуулийн төслийн заалтуудыг хэрэгжүүлэхэд хэдэн тохиолдол байх талаар шүүхээс өмнө шийдвэрлэгдсэн хэргүүдийн хэдэн хувьд нь хариуцагч олдохгүй үндэслэлээр эрэн сурвалжилсан талаарх нээлттэй мэдээлэл байхгүй байна. Гэвч хариуцагчийн эрэн сурвалжлах ажиллагаа нь одоогийн ИХШХШтХ-д зааснаар онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх хэрэгт хамаарах тул сүүлийн гурван жилийн онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэгдсэн маргааны 5 хувь нь хариуцагчийн эрэн сурвалжилсан хэрэг гэж үзвэл нийт тохиолдлын тоо 697 байна.

Хүснэгт 6. Шүүхэд бий болон хүний нөөцийн хэрэгцээ /нийт цаг/

| Үйл ажиллагаа буюу үүрэг | Зарцуулах хугацаа /цаг/ | Тохиолдлын тоо | Хүний нөөцийн хэрэгцээ /нийт цаг/ |
|--|-------------------------|----------------|-----------------------------------|
| Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх мэдэгдлийг гуравдагч этгээдэд хүргүүлэх | 0.66 | 6,530 | 4,309.8 |

| | | | |
|---|------|-------|---------------|
| Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх мэдэгдлийг хэргийн бусад оролцогчдод хүргүүлэх | 0.66 | 6,530 | 4,309.8 |
| Шүүхээс хэргийн оролцогчид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой баримт бичгийг хүргүүлэх <i>Баримт бичгийг баталгаат шуудан, эсхүл биечлэн хүргүүлэх</i> | 1.78 | 5,224 | 9,279 |
| Улсын бүртгэлийн байгууллагаас хэргийн оролцогчийн хаягийг тодруулах | 1.16 | 697 | 808.5 |
| Шүүх өөрийн санаачилгаар баримт бичгийн агуулгыг баримт бичиг хүлээн авах ёстой этгээдэд хоёр удаа нийтэд мэдээлэх замаар мэдэгдэх | 1.5 | 697 | 1,045.5 |
| Нийтэд мэдээлэх замаар баримт бичиг хүргэхдээ шүүх нь бичиг баримтыг хадгалж ямар ч үед баримт бичиг хүлээн авах ёстой этгээдэд гардуулах боломжтой тухай шүүхийн нийтэд мэдээлэх хэрэгслээр мэдээлэх | 0.5 | 697 | 348.5 |
| Нийт | | | 20,000 |

Ингээд тус хуулийн төсөлд тусгагдсан буюу зардал тооцох дээрх заалтуудыг хэрэгжүүлэхэд нийт хүний нөөцийн хэрэгцээт цаг 20,000 цаг байна. Харин доорх хэсэгт бусад үүрэг хүлээсэн байгууллага болох Шүүхийн Ерөнхий Зөвлөл, Улсын Дээд шүүхийн хүний нөөцийн хэрэгцээт цагийг тооцох шаардлагатай бөгөөд тус байгууллагууд нь хуулийн төслөөр ногдуулсан үүргийг зөвхөн нэг удаа гүйцэтгэх тул тохиолдлын тоо 1 байна.

Хүснэгт 7. ШЕЗ болон УДШ-д бий болох хүний нөөцийн хэрэгцээ /нийт цаг/

| Байгууллага | Үйл ажиллагаа буюу үүрэг | Зарцуулах хугацаа /цаг/ | Тохиолдлын тоо | Хүний нөөцийн хэрэгцээ /нийт цаг/ |
|------------------------|---|-------------------------|----------------|-----------------------------------|
| Шүүхийн Ерөнхий Зөвлөл | Шинжилгээ хийх боломжтой этгээдийн талаар мэдээллийн сан үүсгэх | 36 | 1 | 36 |
| | Цахим шуудангийн хаяг мэдүүлэх баримтын загвар батлах | 19 | 1 | 19 |
| Нийт | | | | 55 |

| | | | | | |
|---------------|------|---|----|---|-----------|
| Улсын шүүх | Дээд | Бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэл, хариу тайлбарын загвар батлах | 19 | 1 | 19 |
| | | Бага үнийн дүнтэй хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр боловсруулах аргачлал батлах | 19 | 1 | 19 |
| Нийт | | | | | 38 |

Улмаар нэг албан хаагч жилд 200 ажлын өдөр ажилладаг гэж үзвэл жилд 1600 цаг ажиллах бөгөөд нийт шаардлагатай цагийг шаардлагатай орон тоонд шилжүүлэн байгууллага тус бүрээр авч үзвэл дараах тооцоо гарч байна. Үүнд:

Хүснэгт 8. Шүүхийн болон бусад байгууллагын гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагаанд шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээ /орон тоо/

| № | Байгууллага | Хүний нөөцийн хэрэгцээ /цаг/ | Хүний нөөцийн хэрэгцээ /орон тоо/ |
|-------------|----------------------------------|------------------------------|-----------------------------------|
| 1 | Иргэний хэргийн анхан шатны шүүх | 20,000 | 12,5 |
| 2 | Шүүхийн Ерөнхий Зөвлөл | 55 | 0.03 |
| 3 | Улсын Дээд шүүх | 38 | 0.02 |
| Нийт | | | 12.55 |

Өөрөөр хэлбэл хуулийн төслийн улмаас Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нийт 12.55 орон тооны /шүүгч/ ачаалал бий болгох тооцоо гарч байна. Эдгээрээс шүүхийн ачаалал нь зөвхөн шаардлагатай шүүгчийн орон тоо бөгөөд улмаар мөн тооны шүүгчийн туслахын орон тоо нэмэгдэх юм. Иймд шүүхэд нийт 12.55 шүүгч, мөн тооны туслахын орон тоо бий болох тооцоо гарч байна.

Харин Шүүхийн Ерөнхий Зөвлөл болон Улсын Дээд шүүхийн хувьд хуулийн төслийг улмаас шаардлагатай хүний нөөц үүсэхгүй болно.

1.3. Нийт гарах хүний нөөцийн зардлын тооцоо, холбогдох нэмэлт зардал

Нийт гарах хүний нөөцийн зардлын урьдчилсан тооцоо хийхэд дараах төрлийн зардлын мэдээлэл цуглуулав. Үүнд:

- Цалин, бусад нэмэгдэл, тусламж
- Ажлын байрны, цахилгааны болон бусад материаллаг зардал
- Дагалдах бусад зардал

Өмнөх хэсэгт хуулийн төслөөр шинээр бий болгосон үүргийг хэрэгжүүлэхэд Иргэний хэргийн анхан шатны шүүхэд 12.55 орон тоо шаардлагатай гэж тооцсон. Иймд нийт 12.55 шүүгчийн орон тоотой холбогдох хүний нөөцийн зардлыг анхан шатны шүүхийн шүүгчийн цалингийн цалингаар тооцох шаардлагатай. Үүнд:

Хүснэгт 9. Шаардлагатай орон тооны цалингийн зэрэглэл, хэмжээ

| Албан тушаалын зэрэглэл | Албан тушаалын зэрэглэл | Сарын цалингийн хэмжээ |
|-------------------------|-------------------------|------------------------|
| Шүүх | Анхан шатны шүүгч | 2,700,000 |

Түүнчлэн цалингийн хэмжээг тогтооход үндсэн цалингаас гадна тодорхой нэмэгдлүүдийг⁶ тооцох шаардлагатай бөгөөд эдгээрийн хэмжээг тодорхой гаргах боломжгүй ч шүүгчийн хувьд төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, онцгой нөхцөлийн нэмэгдлийг тус тус оруулан тооцов. Үүнд:

Хүснэгт 10. Шүүгчийн цалингийн зардал /нийт/

| Үндсэн цалингийн хэмжээ | Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл-5% | Онцгой нөхцөлийн нэмэгдэл-40% | Нийт цалин |
|-------------------------|--|-------------------------------|------------------|
| 2,700,000 | 135,000 | 1,080,000 | 3,915,000 |

Ийнхүү байгууллага тус бүрт шаардлагатай орон тооны сарын цалинг дунджаар тооцсон бөгөөд нийт шаардлагатай хүний нөөцийн цалингийн зардлыг байгууллага тус бүрээр дор тооцов. Үүнд:

Хүснэгт 11. Шүүхийн хүний нөөцийн зардал

| Нэмэгдэж буй ачаалал /орон тоо/ | Цалингийн зардал | Хүний нөөцийн нийт зардал | Нийт зардал – 1 жилд |
|---------------------------------|------------------|---------------------------|----------------------|
| Шүүх /12.55 орон тоо - шүүгч/ | 3,915,000 | 49,133,250 | 589,599,000 |
| Шүүх /12.55 орон тоо - туслах/ | 1,858,000 | 23,317,000 | 279,814,000 |

Түүнчлэн цалингаас гадна материаллаг зардлыг авч үзэх шаардлагатай бөгөөд эдгээр байгууллага нь шинээр бий болох орон тоог хангах материаллаг нөөцтэй гэж үзэн бичгийн ширээ, компьютер зэрэг тоног төхөөрөмж шинээр авахтай холбоотой зардал тооцоогүй бөгөөд харин эдгээртэй холбоотой элэгдэл, хорогдлын зардлыг тооцсон. Мөн материаллаг зардлын нарийвчилсан тооцоо гаргахдаа “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”-д жишээ болгон авсан ХЗДХЯ-ы нэг ажилтны материаллаг зардлыг ашиглав. Үүнд:

Хүснэгт 12. Нэг албан хаагчид ногдох материаллаг зардлын хэмжээ

| Зардлын нэр | Зардлын төрөл | Хэмжээ /төгрөг/ |
|---------------|----------------------|-----------------|
| Урсгал зардал | Бичиг хэргийн зардал | 124,000 |
| | Ном, хэвлэл авах | 54,745 |

⁶ Бүх төрлийн даатгал, хоол унааны нэмэгдэл, ажилласан жилийн нэмэгдэл, зэрэг дэвийн нэмэгдэл, шагнал урамшуулал зэрэг болно.

| | | |
|---|-----------------------------------|------------------|
| | Шуудан холбоо | 306,812 |
| | Нийт | 485,557 |
| Барилга, байгууламж, өрөө тасалгааны зардал | Түлш, халаалт | 263,408 |
| | Гэрэл, цахилгаан | 128,239 |
| | Цэвэр, бохир ус | 599,438 |
| | Урсгал зардал | 127,752 |
| | Газрын төлбөр | 22,253 |
| | Нийт | 1,141,090 |
| Элэгдэл, зардал | хорогдлын Техник, тоног төхөөрөмж | 160,000 |
| | Тавилга, эд хогшил | 100,000 |
| | Барилга, байгууламж | 65,670 |
| | Нийт | 325,670 |
| Нийт | | 1,952,317 |

Дээрх тооцооноос үзэхэд нэг албан хаагчид гарах материаллаг зардлын хэмжээ дунджаар 1,952,317 төгрөг байна. Тус тооцоог ашиглан хуулийн төслийн улмаас төрийн байгууллага буюу төсөвт үүсэх нийт хүний нөөцийн ачаалал, зардлыг тооцож гаргав. Үүнд:

Хүснэгт 13. Шүүхийн хүний нөөцийн нийт зардал

| Байгууллага – шаардлагатай орон тоо | Хүний нөөцийн зардал /цалин/ | Материаллаг зардал | Нийт зардал |
|-------------------------------------|------------------------------|--------------------|--------------------|
| Шүүх /12.55 орон тоо - шүүгч/ | 589,599,000 | 24,501,578 | 614,100,578 |
| Шүүх /12.55 орон тоо - туслах/ | 279,814,000 | 24,501,578 | 304,315,578 |
| Нийт | | | 918,416,156 |

Ийнхүү Иргэний хэргийн анхан шатны шүүхэд 1 жилд нийт **918,416,156** төгрөгийн хүний нөөцийн зардал нэмэгдэх тооцоо гарч байна.

Энэхүү тооцооллоос үзэхэд шүүх байгууллагад нийт 12.55 хүний орон тоо шинээр үүсгэх хэмжээний ачаалал нэмэгдэж байгаа тул энэ ачааллыг өнөөгийн байгаа хүний нөөцийн хүрээнд шийдвэрлэснээр хууль бүрэн хэрэгжихгүй байх нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй байна.

Харин хуулийн төслийн 252 дугаар зүйлийн 252.2-т заасан “хэргийн оролцогчийн мэдэгдсэн цахим шуудангаар баримт бичгийг хүргүүлж болно” гэсэн заалтыг идэвхитэй ашиглах нь зүйтэй юм. Өөрөөр хэлбэл, хэргийн оролцогч цахим хаягаа мэдүүлсэн бол

зарчмын хувьд мэдэгдлийг цахимаар хүргүүлж, цахим хаяггүй, цахим хаяг хэрэглэх боломжгүй тохиолдолд баталгаат шуудан эсхүл шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлэх байдлаар зохицуулбал шүүхэд үүсэх зардлын ачааллыг бууруулах боломжтой.

1.4. Бусад нэмэлт зардал, нийт зардлын урьдчилсан тооцоо, хувилбар

Хуулийн төсөлд тусгагдснаар одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ИХШХШТХ-д заагдаагүй хоёр төрлийн шинэ тоголцоог нэвтрүүлэхээр заасан байна. Үүнд: 1. Хуулийн төслийн 3 дугаар хэсгийн 1 дүгээр бүлэг буюу 360-378 дугаар зүйлд Бага үнийн дүнтэй хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа ба 3 дугаар дэд бүлэг болох 311-316 дугаар зүйл буюу Урьдчилсан шүүх хуралдааны зохицуулалтууд юм.

Тиймээс иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дээрх 2 шинэ төрлийн тоголцоог нэвтрүүлснээр төрийн байгууллага буюу шүүхэд нэмэлт зардал, ачаалал үүсэх талаар энэ хэсэгт авч үзье.

ИХШХШТХ-ийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдсан бага үнийн дүнтэй хэрэг маргааныг хянан шийдвэрлэх тогтолцоо нь харьцангуй тодорхой эрх зүйн маргаанаас үүдэлтэй, бага үнийн дүнтэй нэхэмжлэлийн шаардлага бүхий иргэний хэргийн онцлогт тохирсон нотлох баримт бүрдүүлэх, үнэлэх ажиллагааг хялбаршуулж, энгийн болгосон, давж заалдах, хяналтын журмаар хандах хугацааг богиносгох замаар шүүхийн хүртээмжийг нэмэгдүүлэх хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны тусгайлсан төрлийг бий болгох зорилготой.

Энэ хүрээнд хуулийн төслөөр хуулийн этгээдэд шинээр үүрэг бий болгоогүй бөгөөд иргэнд үүсэх ачааллын хувьд ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэгдэх журмаас илүү хялбар, зардал, цаг хугацаа багатай байх хуулийн зохицуулалтыг тусгаж өгсөн. Харин төрийн байгууллагын тухайд хуулийг хэрэгжүүлэгч байгууллага болох шүүхэд тодорхой шинэ үүрэг буюу бага үнийн дүнтэй хэрэг маргааныг хянан шийдвэрлэх илүү хялбарчилсан журмыг тогтоож өгсөн. Гэхдээ бага үнийн дүнтэй хэргийг түргэн шуурхай, зардал багатай, хялбарчилсан журмаар шийдвэрлэх боломжийг бий болгосноор одоо хэрэгжүүлж байгаа процессын журмаас илүү бага зардал шүүхэд үүсэх, түүнчлэн шүүгч болон шүүгчийн туслах, нарийн бичгийн ажлын ачаалал буурах тул нэмэлт зардал процессын үйл ажиллагааны улмаас үүсэхээргүй байна.

Харин гагцхүү бага үнийн дүнтэй хэрэг маргааныг хянан шийдвэрлэх шүүх байгуулсан тохиолдолд шүүхийн байр, дэд бүтцийн зардал үүсч болохоор ба энэхүү хуулийн төсөл нь тусгайлан бага үнийн дүнтэй хэрэг маргааныг шийдвэрлэх шүүх байгуулах тухай хуулийн төсөл биш тул зардлыг тооцох боломжгүй юм.

Мөн одоогийн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд хийгддэгүй ажиллагаа болох урьдчилсан хэлэлцүүлгийг нэвтрүүлснээр нэмэлт зардал үүсэх талаар товч авч үзвэл, иргэний хэргийн шүүхээс иргэний хэрэг үүсгэж, хэргийн үндсэн агуулгын талаар хэлэлцэхгүйгээр урьдчилсан шүүх хуралдаанаар талуудаас гаргах хүсэлтийг шийдвэрлэх, нотлох баримтыг шинжлэн судлах, хэргийн маргаантай үйл баримтыг тодорхойлох зэрэг ажиллагаа хийгдэхээр заасан нь одоогийн мөрдөгдөж буй ИХШХШТХ-ийн шүүх хуралдааны явцад хийгддэг ажиллагааг урьдчилсан хуралдаанаар хэлэлцээр зохицуулсан. Өөрөөр хэлбэл, урьдчилсан хуралдаанаар хэлэлцэх асуудал нь одоогийн хууль тогтоомжид огт байхгүй шинэлэг зохицуулалт бус шүүх хуралдааны явцад хэргийн

оролцогчид хүсэлт гаргах, нотлох баримт цуглуулах зэргээс хамаарч шүүх хуралдаан олон дахин хойшилдог байдлыг засах зорилготой тул уг ажиллагааг хэрэгжүүлснээр шүүхэд нэмэлт ачаалал буюу зардал үүсгэхгүй гэж дүгнэлээ.

Иймд хуулийн төслийн хүрээнд нэмэлт зардал үүсэхгүй бөгөөд харин урьдчилсан шүүх хуралдаан, бага үнийн дүнтэй хэрэг маргааны хянан шийдвэрлэх ажиллагааг тусгайлан зохицуулсан нь одоогийн хууль тогтоомжийн хүрээнд шүүх хуралдаан олон дахин хойшлогддог, бага үнийн дүнтэй ч бусад өндөр үнийн дүн болон маргаан ихтэй хэрэг маргаантай адил хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хийгдэж, улмаар шүүх, иргэн, хуулийн этгээдэд нэмэлт зардал үүсгэдэг байдлыг засах зорилго бүхий хялбаршуулсан журмыг тусгаж буй тул зардлыг багасгах ач холбогдолтой юм. Өөрөөр хэлбэл, дээрх 2 төрлийн тусгай зохицуулалтыг хуулийн төсөлд тусгаснаар нэмэлт зардал үүсэхгүй.

Хоёр. Иргэнд үүсэх зардал, ачаалал

Энэ хэсэгт Аргачлалын дагуу хуулийн төсөлд заасан үүргийг хэрэгжүүлэхэд иргэнд үүсэх зардал, ачааллын хүрээнд хууль тогтоомжид тусгагдсан үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан гарах мөнгөн зардлаас гадна зарцуулах хугацаа буюу ачааллыг тооцно. Ингэхдээ тус хуулийн төсөл нь шинэ хууль буюу анхдагч хуулийн төсөл бус шинэчилсэн найруулга тул шинээр үүрэг, ачаалал бий болгосон зохицуулалтад л зардал тооцов. Зардлыг Аргачлалд заасны дагуу дараах 5 алхам буюу үе шатаар тооцов. Үүнд:

- Үүргийг тогтоох
- Хугацаа зардал тооцох
- Тоон үзүүлэлтийг тооцох
- Нийт дүнг тооцож гаргах
- Хувилбарыг нягталж, хялбарчлах боломжийг шалгах

1.1. Иргэдэд шинээр үүссэн үүрэг

Аргачлалд заасны дагуу иргэнд шинээр үүссэн үүрэг, харилцаанаас үүсэх зардал, ачааллыг тооцох буюу өмнө байсан харилцааг зохицуулсан зохицуулалтад өөрчлөлт ороогүй бол зардал, ачааллыг тооцдоггүй. Энэ хүрээнд тус хуулийн төсөлд иргэнд шинээр үүрэг хүлээлгэсэн дараах зохицуулалт байна. Үүнд:

Хүснэгт 14. Иргэнд шинээр ачаалал бий болгосон заалт

| № | Холбогдох зохицуулалт | Тооцох зардал |
|---|---|---|
| 1 | 67.1.Хэргийн оролцогч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжлэх явцад гуравдагч этгээдэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгааг мэдэгдэнэ. 67.2.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэдэгдэл гаргахдаа түүний шалтгаан болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцыг тусгаж, бичгээр шүүхэд гаргана. | Шүүхэд бичгээр мэдэгдэл гаргах |
| 2 | 131.2.Хэргийн оролцогч маргаантай үйл баримтын хүрээнд эсрэг талаас тодруулга шаардаж, бичгээр хүсэлт гаргана. | Шүүхэд бичгээр хүсэлт гаргах |
| 3 | 314.1.Шүүх хэргийн оролцогчоос урьдчилсан хуралдаанд хэлэх тайлбарыг бичгээр гаргуулна. | Урьдчилсан хуралдаанд хэлэх тайлбараа бичгээр шүүхэд гаргах |

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ИХШХШТХ-д хэргийн оролцогчид амаар болон бичгээр хүсэлт гаргах эрхтэй бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад оролцогчид нь бичгээр хүсэлтээ гаргаж хэвшсэн байдаг. Хэдий тийм ч хуулийн төсөлд тусгагдсан дээрх заалтууд нь одоогийн хуульд тусгагдаагүй шинэ төрлийн үүргийг

хэргийн оролцогчдод ногдуулсан тул иргэнд үүсэх зардлын хүрээнд зардлыг тооцохоор сонгон авав. Түүнчлэн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч нь зөвхөн иргэн бус хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага байх боломжтой тул тус субъектүүдэд үүсэх зардлыг иргэнд үүсэх зардлын хүрээнд багтаан тооцсон болно.

Харин хуулийн төслийн зардлын тооцоо хийх аргачлалын хувьд хуулийн этгээдэд үүсэх зардлыг тусгайлан тооцохоор заасан боловч тус зардал нь хуулийн этгээдийн мэдэгдэх үүрэг, тайлагнах үүрэгтэй хамааралтай тул дээрх зохицуулалтууд нь хуулийн этгээдэд үүсэх зардлын тооцоонд хамаарахгүй болохыг тэмдэглэх нь зүйтэй.

1.2. Хугацаа, зардлын тооцоо

Энэ хэсэгт тодорхойлсон үүргийг гүйцэтгэхэд иргэдээс зарцуулах цаг хугацаа, мөнгөн зардлыг тооцож гаргав. Ингэхдээ:

- Үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлж,
- Үйлдэлд зарцуулах хугацааг тогтоож,
- Тэдгээрт зарцуулах зардлыг тодорхойлов.

Иргэдэд үүсэх цаг хугацааны ачааллыг тооцохдоо стандарт үйл ажиллагааны жагсаалтад үндэслэж зарцуулах цаг хугацааг тодорхойлов. Үүнд:

Хүснэгт 15. Үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай хугацаа, зардал

| № | Үйл ажиллагаа | Хугацаа /мин/ | Зардал /төг/ |
|-------------|-----------------------------|---------------|----------------|
| 1 | Мэдэгдэл бичих, шүүхэд өгөх | 30 | 50,000 |
| 2 | Хүсэлт бичих, шүүхэд өгөх | 30 | 50,000 |
| 3 | Шүүхэд бичгээр тайлбар өгөх | 30 | 50,000 |
| Нийт | | 90 | 150,000 |

Тайлбар: Үйл ажиллагааг гүйцэтгэх алхамыг тооцохдоо хэргийн ээдрээ төвөгтэй болон хялбар хэргүүдэд зарцуулах хугацааг харгалзан тэдгээрийн дунджаар тооцов.

Ийнхүү иргэн, хуулийн этгээд шүүхэд бичгээр мэдэгдэл, тайлбар, хүсэлт гаргахад хамаарах зохицуулалтыг биелүүлэхэд дунджаар **90 мин** зарцуулах бөгөөд хэрэв өөрөө бичих тохиолдолд зардал гарахгүй бөгөөд бусдаар буюу өмгөөлөгчөөр бичүүлэх тохиолдолд тухай бүр өмгөөлөгчид төлөх зардал гарна. Тиймээс өмгөөлөгчийн нэг цагийн хөлсийг дунджаар 100,000 төгрөг гэж тооцвол нийт 90 минут буюу 150,000 төгрөгийн зардал гарахаар байна.

1.3. Тоон үзүүлэлт, нийт ачаалал /зардал, хугацаа/

Тоон үзүүлэлт нь хуулийн төсөлд тусгасан үүрэг хичнээн иргэдэд, нэг жилд хэдэн удаагийн давтамжтайгаар үүрэг хүлээлгэж байгааг илэрхийлнэ. Үүнд:

- Тохиолдлын тоо
- Дамтамжийн тоо

Тохиолдлын тоо, давтамжийн тоог тодорхойлсны дараа тэдгээрийн үржвэрийн тоон үзүүлэлт нь илэрхийлэгдэнэ. Эдгээр зохицуулалтын хувьд давтамжийн тоо 1 байна. Харин тус зохицуулалтыг хэрэглэх тохиолдлын тоог өмнөх хэсэгт авсан 2020-2022 оны хооронд шийдвэрлэгдсэн иргэний хэргийн дундаж болох 26,120 хэргийн 1/4 гэж хийсвэрлэж 6,530 тохиолдол тооцов. Учир нь тус зохицуулалтууд одоогийн хуульд байхгүй бөгөөд бүх хэрэгт гуравдагч этгээд оролцохгүй, бага үнийн дүнтэй хэрэг зэргийг харгалзан үзэж ийнхүү тооцсон болно.

Улмаар өмнөх шатанд тооцож гаргасан үйл ажиллагаа нэг бүрийн зардлыг тоон үзүүлэлт үржүүлж нийт зардлын дүнг гаргавал дараах дүн гарна. Үүнд:

Хүснэгт 16. Иргэдэд бий болох нийт зардал

| № | Үйл ажиллагаа | Хугацаа /мин/ | Тохиолдол | Зардал /төг/ | Тохиолдол |
|-------------|-----------------------------|--------------------|-----------|--------------------|-----------|
| 1 | Мэдэгдэл бичих, шүүхэд өгөх | 30 | 6,530 | 50,000 | 6,530 |
| 2 | Хүсэлт бичих, шүүхэд өгөх | 30 | | 50,000 | |
| 3 | Шүүхэд бичгээр тайлбар өгөх | 30 | | 50,000 | |
| Нийт | | 587,700 мин | | 997,500,000 | |

Ийнхүү хуулийн төсөлд тусгагдсан хэргийн оролцогчоос шүүхэд мэдэгдэл, хүсэлт, тайлбар гаргахтай холбогдох зохицуулалтын хүрээнд сүүлийн гурван жилд шүүхээр шийдвэрлэгдсэн буюу ИХШХШтХ-ийн 115 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэгдсэн иргэний хэргийн дундаж тоогоор бүх тохиолдолд өмгөөлөгч хөлсөлж хийлгэнэ үзвэл иргэдэд **997,500,000** төгрөгийн зардлын ачаалал бий болно.

Гурав. Хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардал

Аргачлалд заасны дагуу тухайн харилцаанд оролцогч хуулийн этгээдийн гүйцэтгэх үүрэгт хуулиар үүрэг хүлээж буй хуулийн этгээдээс хуульд заасан тоо баримт, тайлан бусад мэдээллийг төрийн байгууллага буюу гуравдагч этгээдэд бэлтгэж өгөх, бэлэн байлгах, эсвэл мэдээлэл хүргүүлэхийг ойлгоно⁷. Харин энэхүү хуулийн төслийн хувьд хуулийн этгээдэд зардал, ачаалал үүсгэсэн зохицуулалт агуулаагүй байна.

⁷ Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт, Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо, 2.3 дах хэсэг.

Үнэлгээний үр дүн

Тус хуулийн төслөөр хуулийн этгээдэд шинээр үүрэг бий болгоогүй бөгөөд иргэнд үүсэх ачааллын хувьд зарим төрлийн шинэ зохицуулалт тусгагдсан. Харин төрийн байгууллага буюу шүүхийн тухайд тодорхой шинэ үүрэг бий болгосон. Үүнд:

Шүүхэд үүсэх хүний нөөцийн зардал:

Хуулийн төслөөр шүүхэд шинэ үүрэг, ачаалал бий болгосон зохицуулалтын хүрээнд нийт 12.55 шүүгчийн орон тоо болон мөн тооны шүүгчийн туслахын орон тоо шаардлагатай болох тооцоо гарав. Энэ хүрээнд төрд 1 жилд шүүхийн хүний нөөцийн нийт зардал **918,416,156** төгрөгийн зардал нэмэгдэнэ.

Хүний нөөцийн ачааллыг байгууллагаар авч үзвэл:

| | | |
|---|----------------------------------|--------------|
| 1 | Иргэний хэргийн анхан шатны шүүх | 12.55 |
| 2 | Шүүгчийн туслах | 12.55 |

Энэхүү тооцооллоос үзэхэд хуулийг хэрэгжүүлэгч байгууллага болох иргэний хэргийн анхан шатны шүүхэд үүсч байгаа энэ ачааллыг өнөөгийн байгаа хүний нөөцийн хүрээнд шийдвэрлэснээр хууль бүрэн хэрэгжихгүй байх нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй байна.

Гэхдээ шүүхэд үүсэх зардлын ачааллыг бууруулах зорилгоор хуулийн төслийн 252 дугаар зүйлийн 252.2-т заасан “хэргийн оролцогчийн мэдэгдсэн цахим шуудангаар баримт бичгийг хүргүүлж болно” гэсэн заалтыг идэвхитэй ашиглах нь зүйтэй юм. Өөрөөр хэлбэл, хэргийн оролцогч цахим хаягаа мэдүүлсэн бол зарчмын хувьд мэдэгдлийг цахимаар хүргүүлж, цахим хаяггүй, цахим хаяг хэрэглэх боломжгүй тохиолдолд баталгаат шуудан эсхүл шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлэх байдлаар зохицуулбал шүүхэд үүсэх зардлын ачааллыг бууруулах боломжтой.

Иргэнд үүсэх зардал, ачаалал:

Иргэнд үүсэх ачааллын хувьд хуулийн төсөлд одоогийн хуульд байхгүй бөгөөд зарим төрлийн шинэ зохицуулалт тусгагдсан. Эдгээрийг авч үзвэл иргэн, хуулийн этгээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар гуравдагч этгээдэд мэдэгдэхийн тулд шүүхэд мэдэгдэл хүргүүлэх, тайлбар хүргүүлэх, хүсэлт гаргахад мэргэжлийн өмгөөлөгч хөлсөлсөн тохиолдолд 150,000 төгрөгийн мөнгөн зардал гаргах тооцоо гарч байна. Харин сүүлийн гурван жилд шүүхээр шийдвэрлэгдсэн буюу ИХШХШтХ-ийн 115 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэгдсэн иргэний хэргийн дундаж тоогоор бүх тохиолдолд өмгөөлөгч хөлсөлж хийлгэнэ үзвэл иргэдэд **997,500,000** төгрөгийн зардлын ачаалал бий болно.

Хавсралт 1: Хуулийн төсөлд тусгасан төрийн байгууллагын үүрэг

Хүснэгт 17. Төрийн байгууллагын чиг үүрэг

| № | Зохицуулалт | Зардал тооцох үүрэг |
|--|---|---|
| 1. Иргэний хэргийн анхан шатны шүүх | | |
| 1 | 67.3.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны <u>мэдэгдлийг шүүх гуравдагч этгээдэд хүргүүлнэ.</u> | Шүүхээс гуравдагч этгээдэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэдэгдлийг хүргүүлэх |
| 2 | 67.4. <u>Шүүх</u> хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэдэгдлийг хэргийн бусад оролцогчдод хүргүүлнэ. | Шүүхээс хэргийн бусад оролцогчдод хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэдэгдлийг хүргүүлэх |
| 3 | 251.1.Хуульд өөрөөр заагаагүй бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой баримт бичгийг <u>шүүх өөрийн санаачилгаар хэргийн оролцогчид хүргүүлнэ.</u> | Шүүхээс хэргийн оролцогчид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой баримт бичгийг хүргүүлэх |
| 4 | 252.1.Хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд баримт бичгийг баталгаат шуудангаар, эсхүл шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлнэ. | Баримт бичгийг баталгаат шуудан, эсхүл биечлэн хүргэх |
| 5 | 256.4.Хэргийн оролцогчийн оршин суугаа/оршин байгаа/ болон бусад хүргэх ёстой хаяг мэдэгдэхгүй байгаа тохиолдолд улсын бүртгэлийн байгууллагаас оршин суух хаягийг тодруулах ажиллагааг <u>шүүх санаачилгаараа хийнэ.</u> | Улсын бүртгэлийн байгууллагаас хэргийн оролцогчийн хаягийг тодруулах |
| 6 | 262.3.Шүүх өөрийн санаачилгаар баримт бичгийн агуулгыг баримт бичиг хүлээн авах ёстой этгээдэд <u>хоёр удаа нийтэд мэдээлэх замаар мэдэгдэнэ.</u> | 2 удаа шүүхээс баримт бичгийн агуулгыг нийтэд мэдээлэх |
| 7 | 263.1.Нийтэд мэдээлэх замаар баримт бичиг хүргэхдээ шүүх нь бичиг баримтыг хадгалж ямар ч үед баримт бичиг хүлээн авах ёстой этгээдэд гардуулах боломжтой тухай <u>шүүхийн нийтэд мэдээлэх хэрэгслээр мэдээлнэ.</u> | Нийтэд мэдээлэх хэрэгслээр дамжуулан нийтэд мэдээлэх |
| 2. Шүүхийн ерөнхий зөвлөл | | |
| 8 | 188.3.Шүүхийн ерөнхий зөвлөл шинжилгээ хийх боломжтой этгээдийн талаар мэргэшсэн чиглэлээр нь <u>мэдээллийн сан бүрдүүлнэ.</u> | Шинжилгээ хийх боломжтой этгээдийн талаар мэдээллийн сан үүсгэх |

| | | |
|---------------------------|--|--|
| 9 | 257.3.Энэ хуулийн 257.2-т заасан цахим шуудангийн хаягаа мэдүүлэх <u>баримт загварыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална.</u> | <i>Цахим шуудангийн хаяг мэдүүлэх баримтын загвар батлах</i> |
| 3. Улсын Дээд Шүүх | | |
| 10 | 367.2.Бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэлийн хариу тайлбарын <u>загварыг Улсын дээд шүүх батална.</u> | <i>Нэхэмжлэл, хариу тайлбарын загвар батлах</i> |
| 11 | 377.2.Энэ хуулийн 377.1-д заасан шийдвэрийн боловсруулах <u>аргачлалыг Монгол Улсын дээд шүүхээс батална.</u> | <i>Шүүхийн шийдвэр боловсруулах аргачлал батлах</i> |

Хавсралт 2: Хуулийн төсөлд тусгагдсан хэрэгжүүлэгч байгууллагын үүргийн стандарт үйл ажиллагаа

Хүснэгт 18. Хэрэгжүүлэгч байгууллагуудын гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагаа

| Үйл ажиллагаа буюу үүрэг | Стандарт үйл ажиллагаа | Зарцуулах хугацаа /цаг/ |
|---|--|-------------------------|
| Иргэний хэргийн анхан шатны шүүх | | |
| Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэдэгдлийг гурвадагч этгээдэд хүргүүлэх | Хэргийн оролцогчоос мэдэгдлийг хүлээн авах | 0.08 |
| | Мэдэгдлийг бүртгэх | 0.08 |
| | Мэдэгдлийг хүргүүлэх | 0.5 |
| Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэдэгдлийг гурвадагч этгээдэд хүргүүлэх | Хэргийн оролцогчоос мэдэгдлийг хүлээн авах | 0.08 |
| | Мэдэгдлийг бүртгэх | 0.08 |
| | Мэдэгдлийг хүргүүлэх | 0.5 |
| Шүүхээс хэргийн оролцогчид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой баримт бичгийг хүргүүлэх | Баримт бичгийг бэлтгэх | 0.16 |
| | Хувилах | 0.16 |
| | Баталгаажуулах | 0.3 |
| | Хаягийг тодруулах | 0.16 |
| | Баримт бичгийг хүргүүлэх (биечлэн, эсхүл баталгаат шуудан) | 1 |
| Улсын байгууллагаас бүртгэлийн хаяг тодруулах | Албан бичиг бэлтгэх | 0.5 |
| | Албан бичгийг баталгаажуулах | 0.16 |
| | Улсын бүртгэлийн байгууллагад илгээх | 0.5 |
| Шүүх өөрийн санаачилгаар баримт бичгийн агуулгыг баримт бичиг хүлээн авах ёстой этгээдэд хоёр удаа нийтэд мэдээлэх замаар мэдэгдэх | Нийтэд мэдээлэх баримт бичгийн агуулгыг тодорхойлох | 0.5 |
| | Баримт бичгийн агуулгыг нийтэд мэдээлэх | 0.5 |
| | Баримт бичгийн агуулгыг 2 дахь удаагаа нийтэд мэдээлэх | 0.5 |
| Нийтэд мэдээлэх замаар баримт бичиг хүргэхдээ шүүх нь бичиг баримтыг хадгалж ямар ч үед баримт бичиг хүлээн авах ёстой этгээдэд гардуулах боломжтой тухай шүүхийн нийтэд мэдээлэх хэрэгслээр мэдээлэх | Нийтэд мэдээлэх | 0.5 |
| Шүүхийн Ерөнхий зөвлөл | | |
| Шинжилгээ хий боломжтой этгээдийн мэдээллийн сан бүрдүүлэх | Мэдээлэл цуглуулах | 24 |
| | Мэдээллийг нэгтгэх, загварт оруулах | 3 |
| | Мэдээллийг нягтлах,эцэслэх | 1 |
| | Мэдээллийн сан үүсгэх | 8 |
| Цахим шуудангийн хаяг мэдүүлэх баримтын загвар батлах | Баримтын загвар боловсруулах | 8 |
| | Баримтын загварыг шалгах | 3 |
| | ШЕЗ-ийн хурлаар оруулж батлуулах | 8 |
| Улсын Дээд Шүүх | | |

| | | |
|---|---|---|
| Бага үнийн дүнтэй хэргийн нэхэмжлэл, хариу тайлбарын загвар батлах | Загвар боловсруулах | 8 |
| | Загварыг шалгах | 3 |
| | УДШ-ийн нийт шүүгчдийн хурлаар хэлэлцэж, батлах | 8 |
| Бага үнийн дүнтэй хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр боловсруулах аргачлал батлах | Аргачлал боловсруулах | 8 |
| | Аргачлалын төслийг шалгах | 3 |
| | УДШ-ийн нийт шүүгчдийн хурлаар хэлэлцэж, батлах | 8 |